



СЕКЮРИТИЗ  
ҮЦК

**ГАДААД ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ**

**2022.04.04-2022.04.08**

---




# ГАДААД ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2022.04.11-ний байдлаар

АНУ	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
DOW	34,721.12	0.40%	-1.03%	4.91%	2.42%
S&P 500	4,488.28	-0.27%	-2.64%	6.91%	8.08%
NASDAQ	14,327.26	-1.41%	-6.24%	8.95%	2.86%
Европ	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
GB100	7,669.56	1.56%	1.75%	6.66%	10.90%
DE40	14,283.67	1.46%	-1.13%	3.15%	-6.24%
FR40	6,548.22	1.34%	-2.04%	2.51%	6.14%
IT40	21,050.96	0.95%	-1.37%	3.89%	1.60%
ES35	8,467.40	-0.17%	1.21%	5.43%	0.47%
Ази	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
JP225	26,791.82	-0.72%	-3.03%	8.54%	-9.88%
SHANGHAI	3,251.85	0.47%	-3.13%	-1.33%	-6.81%
CSI 300	4,106.00	-2.94%	-3.65%	-1.60%	-16.97%
CH50	13,662.67	-1.93%	-2.19%	-0.12%	-18.97%
SENSEX	59,447.00	0.70%	0.29%	8.78%	19.87%
Эрчим хүч	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
Газрын тос (Crude Oil)	96.17	-2.14%	-6.86%	-4.93%	61.12%
Газрын тос (Brent)	100.87	-2.08%	-6.37%	-2.63%	59.10%
Байгалийн хий	6.29	0.25%	10.21%	35.06%	145.65%
Шатахуун	3.08	-1.56%	-3.49%	-1.51%	56.68%
Нүүрс	291.60	2.32%	12.70%	-30.68%	213.21%
Түүхий эд	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
Алт	1,944.73	-0.06%	0.64%	-0.33%	12.19%
Мөнгө	24.76	0.02%	1.09%	-0.98%	-0.30%
Зэс	4.69	-0.65%	-1.73%	4.02%	16.48%
Бонд	Өгөөж	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
АНУ	2.78	0.0684	0.38%	0.64%	1.10%
Англи	1.76	0.0290	0.15%	0.23%	0.98%
Швейцар	0.75	0.0390	0.13%	0.47%	1.07%
Испани	1.74	0.0760	0.26%	0.61%	1.36%
Португаль	1.64	0.0420	0.24%	0.65%	1.35%

Эх сурвалж: Trading economics

# ГАДААД ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ



Эх сурвалж: Business Insider

# ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

## АНУ-ын Холбооны Нөөцийн Сан (ХНС) хатуу мөнгөний бодлого баримтлахаа мэдэгдэв

Өнгөрсөн 7 хоногийн ХНС-гийн мэдэгдэл нь а. Бодлогын хүүг хэр хурдтай өсгөх б. ХНС-гийн тайлан дээрх ойролцоогоор 9 их наяд долларын бондыг хэрхэн зарж багасгах талаар байв.

А. ХНС бодлогын хүүг шинжээчдийн таамаглаж байснаас илүү хурдтай буюу дараагийн хурлуудаар 0.5%-иар өсгөж болзошгүй байр суурьтай байгаагаа мэдэгдсэн. ХНС 2000 оноос хойш бодлогын хүүг ийнхүү өндөр хувиар өсгөөгүй тул энэхүү мэдэгдэл нь анхаарал татаж байна. Энэ сард инфляцын түвшин 8%, ажилгүйдлийн түвшин 3.6%-д хүрч, ХНС-гийн бодлогын хүүг 0.5%-иар өсгөх хүлээлт нь эрх баригчдыг хатуу мөнгөний бодлого баримталж магадгүйг харуулж байна.



Б. Өнгөрсөн 7 хоногт ХНС нь бондын үлдэгдлээ хэрхэн багасгах тухайгаа анх удаа мэдээлсэн бөгөөд бодлогын хүүг өсгөхтэй зэрэгцсэн хатуу мөнгөний бодлого баримтлах байр сууриа мөн илэрхийлсэн. ХНС сар бүр 95 тэрбум хүртэлх долларын бондоор балансаа бууруулах төлөвлөгөөтэй байна. Энэ нь бэлэн мөнгөний хэмжээг ихэсгэн урт хугацаат үнэт цаасны өгөөжийг цаашид өсөхөд нөлөөлөх юм.

Эх сурвалж: [www.edwardjones.com](http://www.edwardjones.com)

# ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

## 2017-2019 онуудад өрнөсөн үйл явдлууд

ХНС хамгийн сүүлд 2017-2019 оны хооронд балансын үлдэгдлээ багасгасан. Тухайн үед ХНС бодлогын хүүг нэмэгдүүлснээс 1 жилийн дараагаас сард 50 тэрбум доллароор балансаа бууруулж байсан бөгөөд 2018 оны эцэс хүртэл үргэлжилсэн юм. ХНС-гийн баланс агших үйлдэл эхэлснээс хойш эхний 12 сард хөрөнгийн зах зээл дундаж өсөлтөө хийсээр байсан. 2017 оны 10 сараас 2018 оны 10 сарын хооронд S&P 500 индекс 16% өссөн бол засгийн газрын үнэт цаасны өгөөж 2.3%-иас 3% болж өссөн.

Баланс бууруулж эхэлснээс хойш хоёрдох жилд засгийн газрын үнэт цаасны өгөөж 3.23%-иас буурсан ба S&P 500 индекс 20%-ийн засварын хөдөлгөөн хийж унасан юм. 2018 оны 3-р улиралд ДНБ-ний өсөлт 2%-иас доош орсон нь мөнгөний бодлогыг зөөлрүүлэх дохио болж байсан.



Эх сурвалж: U.S. Bureau of Economic Analysis

Шинжээчдийн таамаглаж буйгаар энэ удаагийн ХНС-гийн хатуу мөнгөний бодлого болон баланс бууруулах үйлдэл нь 2017-2019 онд өрнөсөн үйлдэлтэй зарим хэсгээрээ адил байж болох юм. Гэвч энэ удаагийн хүчтэй эдийн засгийн өсөлт болон өндөр инфляцын түвшинтэй нөхцөл байдал өмнө баримталсан бодлоготой хэр нийцэх нь анхаарал татаж байна.

Эх сурвалж: [www.edwardjones.com](http://www.edwardjones.com)

# ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

**Шинжээчдийн үзэж байгаагаар эдийн засгийн үзүүлэлтүүд энэ жилдээ өсөлт саарах дохио өгч байгаа ч эдийн засгийн хямрал болохооргүй байна**

ХНС-гийн хэдэн арван жилд үзэгдээгүй хатуу мөнгөний бодлого нь эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүлэлгүйгээр өндөр инфляцын түвшинг хэрхэн хяналтад оруулан буулгаж болохыг дараах схемээр харуулав.



**Худалдан авагчдын хандлага:** Муу

**Бондын өгөөж:** 10-2 жилийн өгөөж урвуу болсон боловч 10-3 жилийн өгөөж хэвийн байна

**ХНС-гийн бодлого:** Зөөлөн мөнгөний бодлогыг хатуу болгож байгаа

**Инфляцын түвшин:** Өндөр

**Түүхий эдийн ханш:** Хурдтай өссөн ч дээд цэгтээ хүрсэн гэж харж байна

**Ажлын байрны нэмэлт:** Өндөр

**Ажилгүйдлийн түвшин:** Түүхэн доод хэмжээнд

**Өрхийн хадгаламж:** Дунджаас дээгүүр

**Компаниудын ашиг:** Өсөж байгаа ч буурсан үзүүлэлттэй болсон

**Үйлдвэрлэлийн индексүүд:** Сайн байгаа ч ДНБ-ийн өсөлтийн хурд саарч байгааг илэрхийлсэн

- Түүхэн үзүүлэлтээс харахад эдийн засгийн хямралууд ихэвчлэн ажилгүйдлийн түвшин өсөж байхад болдог. Өнгөрсөн 7 хоногт шинэ ажлын байрны тоо болон ажилгүй хүмүүсийн тооны харьцаа 1968 оноос хойших хамгийн сайн үзүүлэлттэй гарсан нь иргэдийн цалин энэ жилдээ хангалттай байхыг харуулж байна.
- Хэдий өрхийн хадгаламж их, өр төлбөрийн түвшин бага байгаа ч эрчим хүчний үнэ болон инфляцын түвшин өндөр байгаа нь худалдан авагчдын итгэлийг бууруулж эдийн засгийн өсөлтийг сааруулах эрсдэлтэй байна.
- Бизнесүүдийн хувьд, үйлдвэрлэлийн индекс өссөн үзүүлэлттэй байгаа ч өнгөрсөн сарын түвшин 2020 оны 9 сарын доод түвшинд хүрсэн нь үйлдвэрлэл болон эрэлт буурч байгаа дохио өгч байна.
- 10 болон 2 жилийн хугацаатай засгийн газрын үнэт цаасны өгөөж урвуу болсон боловч 10 болон 3 жилийн хугацаатай засгийн газрын үнэт цаасны өгөөж хэвийн байгаа нь эдийн засгийн хямрал болох дохио улаан биш шар өнгөтэй байгааг харуулж байна.

**Дүгнэлт:** Дээрхээс харахад эдийн засгийн өсөлт саарч байгаа ч хямрал болох магадлал харьцангуй бага байна.